



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 4/184

Батноров сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 86 дугаар тушаал (Орон нутгийн хөгжлийн сангийн журам)-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй "Сумын төвийн гудамжны гэрэлтүүлэг нэмэх" ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, гэрээнд заагдсан хугацаанд тус ажлыг бүрэн гүйцэд хийлгэн хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Ган-Эрдэнэ (Засаг даргын орлогч)
Гишүүд: Г.Цолмонтаяа (Соёл сангийн нягтлан бодогч)
Э.Баяртулга (Дундбүрд багийн Засаг дарга)
Г.Ганбаяр (Хэсгийн төлөөлөгч)
Р.Наранбаатар (ШҮЗТ)

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээ, явцын чанар, ажлын тоо хэмжээ, гэрээний хэрэгжилт, гүйцэтгэлд захиалагч байгууллагыг бүрэн төлөөлж хөндлөнгийн хяналт шалгалтыг тогтмолжуулан удирдлагыг мэдээллээр хангаж, мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх, явцын дүгнэлт, гүйцэтгэлд акт үйлдэн тус ажлыг бүрэн хүлээж авах ажлыг хариуцлагатай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.



Б.ЖАВХЛАНБАЯР

230423316